



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл
ажиллагааны үр нөлөө

АУДИТЫН КОД: ГСА-2022/32-3-ШТА-ГА

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа,
Утас: 70543156
Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр,
Утас: 70543179
Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn
Аудитор: С.Батцэцэг, Утас: 70543179
Цахим хаяг: Battsetsegsa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn

Тайланг бэлтгэсэн:

Говьсүмбэр аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор
Б.Сарантуяа

Аудитын менежер

Аудитор Г.Наранбаяр
С.Батцэцэг

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал
70543156, 70543179
дугаарын утсаар харилцана
уу.

ХАЯГ:

Сүмбэр сум 3-р баг,
Нутгийн удирдлагын
ордон, 205 тоот

2022 оны 10 дугаар сар

АГУУЛГА

АГУУЛГА 2

ТОВЧИЛСОН ҮГС 3

БҮЛЭГ 1. Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр төрөөс баримталж буй бодлого, эрх зүйн зохицуулалтууд бүрэн хэрэгжиж чадаагүй нь ЖДҮГ болон аймгийн ХХААГ-тай учлаа холбоотой ажиллаагүйтэй холбоотой байна. 8

1.1. Орон нутагт жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн боловч төрийн байгууллагуудын үйл ажиллагаа уялдаа холбоогүй байна. 8

1.2 ЖДҮХС-гаас хуваарилан олгох хөрөнгийн төлөвлөлтөд орон нутгийн оролцоо байхгүй байна. 10

БҮЛЭГ 2. ЖДҮХС-аас олгосон зээлийн 25.0% нь үр дүнгүй зарцуулагдаж, сонгон шалгаруулсан төсөл хэрэгжээгүй байна. 11

2.1 Төсөл сонгон шалгаруулах дэд хороог аймгийн Засаг даргын захирамжаар журмын дагуу жил бүр 8 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна. 11

2.2 ЖДҮХС-аас олгосон зээлийн 43.9% нь буюу 500.0 сая төгрөгийн зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй байна. 13

БҮЛЭГ 3. ЖДҮГ болон аймгийн ХХААГ-аас төслийн хэрэгжилтэд тавих хяналт үр дүнгүй, зээлийн мэдээллийн цахим системийн зохион байгуулалт, ашиглалт хангалтгүй байна. 19

3.1 Хэрэгжсэн төслүүдээс орон нутгийн бренд бий болоогүй ч 68.7% нь үйл ажиллагаа нь өргөжиж, бүтээгдэхүүний нэр төрлөө нэмэгдүүлсэн байна. 19

3.2 ЖДҮГ болон аймгийн ХХААГ-аас төслийн хэрэгжилтэд тавих хяналт үр дүнгүй, зээлийн мэдээллийн цахим системийн ашиглалт, хүчин чадал хангалтгүй байна. 21

ДҮГНЭЛТ 23

ЗӨВЛӨМЖ 24

ДЭЭД ШАТНЫ БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛЭХ САНАЛ 25

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН 26

САНАЛ 26

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН 29

САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР 29

ТОВЧИЛСОН ҮГС

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АЗД	Аймгийн Засаг дарга
АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
ААН	Аж ахуйн нэгж
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр
ЖДҮГ	Жижиг, дунд үйлдвэрийн газар
ЖДҮХС	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх
үндэслэл,
бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2022 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаал, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийлээ.

Аудитын
зорилт:

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны үр нөлөөг тооцож, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдсэн.

Аудитын зорилтыг хангахын тулд аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд:

- Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр төрөөс баримталж буй бодлого, эрх зүйн зохицуулалтад ЖДҮХС-ийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, үр дүн, үр нөлөөг тооцох асуудал зохих түвшинд тодорхойлогдсон эсэх
- ЖДҮ-ийн сонгон шалгаруулалт, зээлийн зориулалт, зарцуулалт хууль тогтоомж, дүрэм журам зэрэг холбогдох шаардлага, шалгуурын дагуу үр дүнтэй эсэх
- ЖДҮ-ийн сонгон шалгаруулалт, зээлийн зориулалт, зарцуулалт хууль тогтоомж, дүрэм журам зэрэг холбогдох шаардлага, шалгуурын дагуу үр дүнтэй эсэх

Аудитад
ашигласан
шалгуур
үзүүлэлт:

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- ✓ Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 4-6 дугаар зүйл, 8-13 дугаар зүйл, 16-20 дугаар зүйл /2019/
- ✓ Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3.5, 16 дугаар зүйл /2019/
- ✓ Коронавируст халдвар /КОВИД19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.26,
- ✓ 2019 оны 156 дугаар тогтоолоор баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр”
- ✓ 2020 оны 113 дугаар тогтоолоор баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”,
- ✓ 2016 оны 138 дугаар тогтоолоор батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэх хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах түр журам”
- ✓ 2017 оны 89 дүгээр тогтоол “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”
- ✓ Аймгийн ИТХ-ын 2016 оны 75 дугаар тогтоолоор баталсан “Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих дэд хөтөлбөр”
- ✓ Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- ✓ Говьсүмбэр аймгийн эдийн засаг, нийгмийг 2019, 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл

Аудитын
хамарсан
хүрээ:

Аудитад аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газар, ЖДҮХС-аас зээл олгох, төсөл сонгон шалгаруулах дэд хороо, Хүнс, хөдөө, аж ахуйн газрын ЖДҮ хариуцсан мэргэжилтэн, ЖДҮХС-ийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан иргэн, аж ахуй нэгж байгууллагуудын 2019-2020 оны үйл ажиллагааг хамруулав.

Аудитын арга
зүй:

Аудитыг АДБОУС (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-6:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/81 дүгээр тушаал, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудит хийх
багийн
бүрэлдэхүүн,
хугацаа:

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, аудитор С.Батцэцэг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын талбарын ажлыг 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс эхлүүлж, төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу үе шатны ажлыг гүйцэтгэн тайланг Тэргүүлэх аудиторовын тушаалаар баталгаажуулан шалгагдагч байгууллага болон холбогдох эрх бүхий албан тушаалтанд 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдөр хүргүүлээ.

Хүндрэл
бэрхшээл:

Аудитыг гүйцэтгэх хугацаанд “Хог хаягдлын менежмент, түүний хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудиттай аудитын хугацаа давхардсан, 2 орон тоо дутуу ажиллаж байгаагаас аудитын багт хүний нөөцийн дутагдал үүссэн, мөн ЖДҮГ нь аймгийн ХХААГ-тай уялдаа холбоотой ажилладаггүйгээс ЖДҮХС-гаас зээл авсан ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагаатай холбоотой аудитад шаардлагатай баримт материалуудыг дутуу ирүүлсэн нь аудитад хүндрэл учруулж байлаа.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Жижиг, дунд, үйлдвэр, үйлчилгээг дэмжих чиглэлээр Монгол Улсын Засгийн газраас үндэсний хөтөлбөр, аймаг орон нутгийн зүгээс дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна.

Жижиг, дунд, үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6, 11.7, Засгийн газраас 2020 оны 113 дугаар тогтоол “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, хяналт тавих журам”-ын 3.2 дахь хэсэгт ЖДҮ-ийн зээлд хамрагдах ААН-ийн ангилал, борлуулалтын орлогод тавигдах шаардлага, зээлийн хэлбэр, ажилтны тоо, 1 удаа олгох зээлийн хэмжээ зэргийг заасан байна.

ХХААХҮС-ын 2019 оны А/41, 2020 оны А/131 дүгээр тушаалаар Говьсүмбэр аймагт 2019-2020 онд ЖДҮХС-аас нийт 1.0 тэрбум төгрөгийн зээл олгох эрх, хөнгөлөлттэй зээл олгох салбар, чиглэлийг баталсан бөгөөд нийт 1,139.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон байна. Тухайлбал:

1. 2019 онд 10 аж ахуйн нэгж, иргэнд 691.0 сая,
2. 2020 онд 6 аж ахуй нэгжид 448.0 сая төгрөг тус тус олгосон байна.

ЖДҮХС-аас 2019 онд авсан хөнгөлөлттэй зээлүүдийг салбар, чиглэлээр ангилж үзвэл:

Хүснэгт №1

№	Зээл олгох салбар, чиглэл	2019 он			
		Иргэн		ААН	
		Тоо хэмжээ	Үнийн дүн /сая.төг/	Тоо хэмжээ	Үнийн дүн /сая.төг/
1	Арьсан эдлэл үйлдвэрлэл бэлэг дурсгал	1	40.0		
2	Гэрэл зураг, хэвлэлийн үйлчилгээ, худаасан хэвлэл			1	50.0
3	Модон эдлэл үйлдвэрлэл			2	73.4
4	Мах, махан бүтээгдэхүүн, дайвар бүтээгдэхүүн үйлдвэрлэл			2	185.6
5	Оёдол захиалга	1	35.0		
6	Тавилга үйлдвэрлэл	1	20.0		
7	Гутлын салон, тавилга үйлдвэрлэл	1	46.0		
8	ЖДҮГ-аас шууд олгосон			1	241.0
Нийт дүн		4	141.0	6	550.0

Хүснэгтээс харахад: ЖДҮХС-аас 10 иргэн, ААН зээл авсан боловч 1 зээлдэгч “Чойр кашмер” ХХК-241.0 сая төгрөг нь ЖДҮГ-аас, 9 зээлдэгч буюу иргэд А.Сэргэлэн-40.0 сая, З.Билэгбаяр-35.0 сая, Г.Мөнх-Од-20.0 сая, Э.Мөнхзул-46.0 сая, ААН “Боржигин нутгийн зураг” ХХК-50.0 сая, “Жанжин Чойрын Бөхбат хийц” ХХК-30.0 сая, “Очир мөнх хайрхан” ХХК-35.6 сая, “Мөнх авзага хайрхан” ХХК-43.4 сая, “Сүмбэр буянт” ХХК-150.0 сая төгрөгийг тус тус орон нутагт хуваарилагдсан сангийн хөрөнгөөс нийт 450.0 сая төгрөгийн зээл авсан байна.

ЖДҮХС-аас 2020 онд авсан хөнгөлөлттэй зээлүүдийг салбар, чиглэлээр ангилж үзвэл:

Хүснэгт №2

№	Зээл олгох салбар, чиглэл	2020 он			
		Иргэн		ААН	
		Тоо хэмжээ	Үнийн дүн /сая.төг/	Тоо хэмжээ	Үнийн дүн /сая.төг/
1	Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулалт			1	64.0
2	Сав баглаа боодол			1	60.0
3	Мах, махан бүтээгдэхүүн, дайвар бүтээгдэхүүн үйлдвэрлэл			1	71.0
4	Аялал жуучлал зоогийн өргөө			1	58.0
5	Хүлэмжийн аж ахуй			1	95.0
6	Зоорь стандарт хадгалалт			1	100.0
Нийт дүн				6	448.0

Хүснэгтээс харахад: ЖДҮХС-аас орон нутагт хуваарилагдсан сангийн хөрөнгөөс 6 ААН нийт 448.0 сая төгрөгийн зээл авсан ба 2020 оноос эхлэн иргэдэд зээл олгохгүй, зөвхөн ААН-д зээл олгох чиглэл баримталсан байна. Тухайлбал: “УЦЦЭЧ” ХХК-71.0 сая, “Чойр нарлаг хүлэмж хоршоо”-95.0 сая, “Чойрын богд шүтээн” ХХК-58.0 сая, “Мэргэн-Дунгаа” ХХК-64.0 сая, “Эрин зууны холбоос” ХХК-60.0 сая төгрөгийн зээл авсан байна.

Дүрслэл товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн орон нутгийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан заалтууд	8
Дүрслэл 2	Төслийн сонгон шалгаруулалтын онооны системээр үнэлэх үе шат	11
Дүрслэл 3	ЖДҮХС-гаас олгосон зээлийн ангилал /салбараар/	12
Дүрслэл 4	Төслийн шийдвэрлэлттэй холбоотой тоон мэдээлэл	12
Дүрслэл 5	ЖДҮХС-гийн зээлийн сонгон шалгаруулалтын үе шат	13
Дүрслэл 6	ХХААГ-д бүртгэлтэй аж ахуйн нэгжлийн судалгаа	14
Дүрслэл 7	Төслийн сонгон шалгаруулалтын онооны системээр үнэлэх үе шатууд	19

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	ЖДҮХС-аас 2019 онд авсан хөнгөлөлттэй зээлүүдийг салбар, чиглэлээр	6
Хүснэгт 2	ЖДҮХС-аас 2020 онд авсан хөнгөлөлттэй зээлүүдийг салбар, чиглэлээр	6

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	“Боржигин нутгийн зураг” ХХК-ны хийсэн хөргөгчний наалт, хулдаасан хэвлэлийн машин	14
Зураг 2	“Боржигин гоёл” ХХК-ны ажлын байр, хийсэн бүтээлүүд	15
Зураг 3	А.Сэргэлэнгийн арьсан эдлэлүүд/үзэгний сав, түлхүүрийн оосор, арьсаар бүрсэн авдар/ даавуу торны зурган хэвлэл	15
Зураг 4	“Эрин зууны холбоос” ХХК-ны даавуу уут, аранзны дэлгээш, барилгын дулаалгатай блок	15
Зураг 5	Зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй ЖДҮ эрхлэгч “Чойр нарлаг хүлэмж хоршоо”	16

БҮЛЭГ 1


Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр төрөөс баримталж буй бодлого, эрх зүйн зохицуулалтууд бүрэн хэрэгжиж чадаагүй нь ЖДҮГ аймгийн ХХААГ-тай уялдаа холбоотой ажиллаагүйтэй холбоотой байна.

1.1. Орон нутагт жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн боловч төрийн байгууллагуудын үйл ажиллагаа уялдаа холбоогүй байна.

1.1.1 Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих чиглэлээр дэд хөтөлбөрийг хууль, журамд заасны дагуу баталсан байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 75 дугаар тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийг баталж, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, жил бүрийн “Аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл”-д хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан тусгасан байна.

Дүрслэл №1



“Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх” дэд хөтөлбөрт тусгагдсан 3 зорилтын хүрээнд 12-15 арга хэмжээг төлөвлөж, төсвийг аймгийн Засаг даргын захирамжаар жил бүр баталсан байна. Тухайлбал: 2019 онд 28.0 сая, 2020 оны 25.0 сая төгрөг тус тус баталсан байна.

Аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс 2019, 2020 оны дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2019 онд 91.0%, 2020 онд 82.8%-тай тус тус үнэлсэн байна.

1.1.2 Кластераар хөгжүүлэх бодлого, чиглэлийн талаар аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан боловч хэрэгжилт хангалтгүй байна.

Кластераар хөгжүүлэх бодлого, чиглэлийн талаар 2016-2020, 2020-2024 оны аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдаагүй бөгөөд аймгийг 2021-2025 онд

хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн “4.Эдийн засаг” зорилгын хүрээнд зорилт 4.5.2¹-д тусгасан боловч энэхүү зорилтын хүрээнд хийх ажлыг нарийвчлан төлөвлөөгүйгээс хэрэгжилт хангалтгүй байна.

Кластерийн зарчмаар гэдэг нь Үйлдвэрлэл, үйлчилгээ нь хорших, төрөлжих хэлбэрээр харилцан уялдаатай ажиллах тухай ойлголт бөгөөд үндсэн чиглэлд тусгасан тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагуудын оролцоо тодорхойгүй, хэнд, ямар арга замаар дэмжлэг үзүүлэх талаар тодорхой чиглэл байхгүйгээс энэ заалт огт хэрэгжээгүй байна. Тухайлбал: хэн, ямар зохион байгуулалтаар, хэрхэн хэрэгжүүлэх талаар ЖДҮ хариуцсан төрийн байгууллагууд болоод ЖДҮ эрхлэгч нарын ойлголт хангалтгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1², 9 дүгээр зүйлийн 9.4³, 15 дугаар зүйлийн 15.1.2⁴, 18 дугаар зүйлийн 18.3⁵, Засгийн газрын 2019 оны 156 дугаар тогтоолын хавсралт “ЖДҮ-г дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн 4 дүгээр зүйлийн 4.5.8⁶ дахь заалтуудыг зөрчсөн байна.

Иймд аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичиг буюу аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 4.5.2 дахь заалтыг жилийн төлөвлөгөөнд дэлгэрэнгүй тусгаж, үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

1.1.3 Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлд төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхойлсон боловч ЖДҮГ болон аймгийн ХХААГ-уудын ажлын уялдаа холбоо хангалтгүй байна.

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төрийн байгууллагуудын бүтэц, чиг үүрэг, уялдаа холбоог оновчтой тодорхойлоогүйгээс орон нутгийн зүгээс зээлдэгч нарын үйл ажиллагаанд хяналт тавих нөхцөл байдал хязгаарлагдсан, ЖДҮГ, аймгийн ХХААГ-ууд уялдаа холбоогүй ажиллаж байна. Тухайлбал: Зарим иргэн, ААН-үүд аймгийн ХХААГ болон төсөл сонгон шалгаруулах дэд хороогоор дамжилгүй шууд ЖДҮХС-гаас зээл авсан тохиолдолд орон нутгийн холбогдох байгууллагад мэдээлэл хүргүүлдэггүй, зээл олгосон болон зээлийн эргэн төлөлтийн мэдээлэл хангалтгүй байна. Говьсүмбэр аймагт 2019 онд 500.0 сая төгрөгийн зээл олгохоор батлагдаж, 450.0 сая төгрөгийн зээл олгосон боловч ЖДҮХС-гаас 691.0 сая төгрөгийн зээл олгосон мэдээлэл ирүүлсэн байна. Энэ нь 2019 онд “Чойр Кашмер” ХХК шууд ЖДҮГ-т төслөө хүргүүлэн 241.0 сая төгрөгийн зээлийг ЖДҮХС-аас авсан боловч ЖДҮГ-аас зээлэгч нарын мэдээллийг тухай бүр ирүүлдэггүйгээс шалтгаалан аймгийн ХХААГ-аар дамжаагүй учраас ямар ч мэдээлэлгүй, аймгийн тайлан, мэдээнд тусгахгүй явж ирсэн байна.

2019-2020 онд ЖДҮХС-гаас нийт 16 төсөлд зээл олгосон бөгөөд аймгийн ХХААГ нь 2019 онд арилжааны банкаар дамжуулан олгосон 9 зээлийн гэрээний хуулбар, 2020 оны ЖДҮГ-аас олгосон 6 зээлдэгчийн зээл төлөх хуваарийг аудитад хамрууллаа. Мөн 2019 онд ЖДҮХС-гаас шууд олгосон “Чойр кашмер” ХХК-ийн 241.0 сая төгрөгийн зээлтэй холбоотой баримт материал аймгийн ХХААГ-т байхгүй, төсөлтэй холбоотой баримт материалыг ЖДҮГ-аас гаргуулан авахаар албан бичиг хүргүүлсэн боловч аудитын явцад баримт материалыг ирүүлээгүй тул аудитад хамрагдаагүй болно.

Аймгийн ХХААГ-ын хяналт тавих чиг үүргийг гэрээгээр зохицуулаагүйгээс 2019 оны зээлдэгч нараас зээлийн гэрээг хуулбарлан авч архивласан бол 2020 оны 6 зээлдэгчийн зээлийн гэрээний хавсралт зээл төлөх хуваарийг ЖДҮГ-аас аймгийн ХХААГ-т ирүүлсэн байна. Уг баримт бичиг нь зээлдэгчийн гарын үсгээр баталгаажаагүй байна.

Орон нутгаас буюу аймгийн ХХААГ-ын ЖДҮ хариуцсан мэргэжилтэн ЖДҮХС-гаас зээл авсан зээлдэгч нарын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэгтэй боловч энэ чиг үүргийг нарийвчлан гэрээгээр зохицуулаагүйгээс энэ чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн байна. ЖДҮГ-аас орон нутгийн оролцоог хангахгүй байгаа бөгөөд аймгийн ХХААГ

¹ 4.5.2 Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийн бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын тогтолцоог кластерийн зарчмаар хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх

² 9.1.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг кластераар хөгжүүлэхэд төрөөс дараах дэмжлэгийг үзүүлнэ

³ 9.4.Орон нутагт кластерын хэлбэрээр үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжийн төсөл нь энэ хуулийн 15.1.2-т заасан чиглэлд хамаарч байвал төрөөс тэргүүн ээлжинд дэмжинэ.

⁴ 15.1.2.орон нутгийн түүхий эдийн нөөц, эрэлт, хэрэгцээ, энэ хуулийн 18.3-т заасан саналыг харгалзан кластераар бүсчлэн хөгжүүлэх чиглэлийг батлах

⁵ 18.3.Тухайн шатны Засаг дарга жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг кластераар хөгжүүлэх тухай саналаа боловсруулж, дээд шатны эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.

⁶ 4.5.8. жижиг, дунд үйлдвэрийн кластер байгуулах, нэгдэх санал санаачилгыг дэмжиж, кластерт бүртгэлтэй аж ахуйн нэгж, иргэнд нэн тэргүүнд хөнгөлөлт олгох.

нь гэрээний оролцогч болж чадахгүй байгаа тул зээлдэгч нарын болон ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааны талаарх мэдээллээр бүрэн хангагдаж чадахгүй байна.

Цаашид ЖДҮХС-гаас зээл олгохдоо аймгийн ХХААГ-ыг оролцуулсан гурвалсан гэрээ байгуулах замаар орон нутгийн оролцоог хангах, зээлдэгчийн болон зээлийн эргэн төлөлтийн мэдээллийг тодорхой давтамжтайгаар харилцан солилцож ажиллах нь зээлийн ашиглалт, эргэн төлөлт сайжрах боломжийг бүрдүүлэх юм. ЖДҮГ-т уламжлах саналаар хүргүүлэхээр шийдвэрлэв.

1.2 ЖДҮХС-гаас хуваарилан олгох хөрөнгийн төлөвлөлтөд орон нутгийн оролцоо байхгүй байна.

ЖДҮГ-аас орон нутгийн хүн ам, ЖДҮ эрхлэгчдийн тоо, өмнөх оны зээлийн эргэн төлөлтөд үндэслэн төлөвлөж хуваарилдаг бөгөөд ЖДҮХС-гаас хуваарилж буй хөрөнгийн төлөвлөлт орон нутгийн оролцоогүйгээр хийгдэж ирсэн байна.

1.2.1 Зээлийг арилжааны банкны журмаар олгох нь төрөөс баримталж буй бодлого, шийдвэртэй нийцэхгүй байна.

ЖДҮХС-гаас арилжааны банкны журмаар олгосон зээл нь Монгол банкинд бүртгэгддэг, зээлийн эргэн төлөлт сайн хийгдэж байгаа давуу талтай боловч зээлдэгч нарын зээлийг зориулалтын дагуу ашиглаж үйл ажиллагаа нь тогтмолжсон эсэх, ажлын байр нэмэгдсэн эсэх зэрэг төрөөс баримталж буй бодлогын хэрэгжилтэд гол анхаарлаа хандуулах нь сул байна. Арилжааны банкууд зөвхөн зээлийн эргэн төлөлтөд гол анхаарлыг хандуулж байна.

Арилжааны банкаар дамжуулан олгож буй зээл нь ЖДҮ эрхлэгчдийн хувьд шат дамжлага ихсэх, зээлийн шалгуур өндөр болох, барьцаа хөрөнгө хүрэхгүй байх, төсөл бичсэн зээлийн хэмжээ хасагдах, ЖДҮХС-аас авсан зээлээрээ буцаан банкны бизнесийн зээлийг хаах зэрэг хүндрэл бэрхшээл үүсдэг төдийгүй, тухайн зээлийн хөрөнгө зориулалтын дагуу зарцуулагдсан эсэх, ЖДҮ эрхлэгчийн үйл ажиллагаа хэвийн явагдах эсэхэд арилжааны банкны зүгээс ач холбогдол өгөх нь бага, зээлийн батлан даалтын сангаас зээл олгох сонирхолгүй байдаг зэрэг нь төрөөс баримталж буй бодлого шийдвэртэй нийцэхгүй байна.

Иймд ЖДҮХС-аас олгож буй хөнгөлөлтэй зээлийг ЖДҮ эрхлэгч нарт арилжааны банкаар дамжуулан олгохгүй байх бодлогыг баримтлах нь зүйтэй тул саналыг ЖДҮГ-т уламжлах саналаар хүргүүлэхээр шийдвэрлэв.

БҮЛЭГ 2

ЖДҮХС-аас олгосон зээлийн 43.9 % нь үр дүнгүй зарцуулагдаж,
сонгон шалгаруулсан төсөл хэрэгжээгүй байна.

2.1 Төсөл сонгон шалгаруулах дэд хороог аймгийн Засаг даргын захирамжаар журмын дагуу жил бүр 8 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

2.1.1 Төсөл сонгон шалгаруулах дэд хороог орон нутагт журмын дагуу байгуулсан байна.

Аймгийн төсөл сонгон шалгаруулах дэд хороог Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/119 дүгээр тушаал, 2020 оны А/131 дүгээр тушаалаар баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.8⁷-д заасны дагуу аймгийн Засаг даргын захирамжаар жил бүр 8 хүний бүрэлдэхүүнтэйгээр, аймгийн ХХААГ-ын даргын тушаалаар иргэн, ААН-үүдээс ирсэн төслийн иж бүрдлийг шалгаж хүлээн авах ажлын хэсгийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Төсөл сонгон шалгаруулах дэд хороог байгуулахдаа “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.3⁸-д заасны дагуу хорооны бүрэлдэхүүнд орон нутгийн төрийн байгууллагын төлөөлөл 3, төрийн бус байгууллагын төлөөлөл 4, хорооны нарийн бичгийн даргаар аймгийн ХХААГ-ын ЖДҮ хариуцсан мэргэжилтэн саналын эрхгүй оролцсон байна.

Дэд хороо нь аймгийн жижиг, дунд үйлдвэрийн төслийг сонгон шалгаруулж, эрэмбэлсэн жагсаалтыг батлуулах чиг үүрэгтэй ажиллаж байна. 2019-2020 онд төсөл сонгон шалгаруулах дэд хороо нь нийт 5 удаа хуралдаж, дэд хорооны 4 тогтоол гаргасан ба 2 удаагийн хурлын тэмдэглэлийг хөтөлж архивласан байна. Тухайлбал: жил бүр “Төсөл сонгон шалгаруулах дэд хорооны хурлын дэг батлах тухай, “Сонгон шалгаруулалтын дүн батлах тухай” тогтоолууд гарсан байна.

Төслийн сонгон шалгаруулалтын онооны системээр үнэлэх үе шатуудыг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл 2



Дүрслэлээс харахад: Зээл хүссэн иргэн, ААН-үүдээс ирсэн төслүүдэд хийгдэж байгаа иж бүрдлийн болон онооны системээр үнэлэх судалгааны үе шатуудад 70-аас доош үнэлэгдсэн төслүүдийг хасаж байгаа нь оноо өндөр авахын тулд төсөлд хийсвэр тоо бичдэг байх магадлалтай байна.

Дэд хороо нь тогтоолоор эрэмбэлсэн жагсаалтыг аймгийн Засаг даргын захирамжаар батлуулан, ЖДҮГ-т хүргүүлдэг.

⁷ 6.8 Хорооны бүрэлдэхүүнийг Жижиг, дунд үйлдвэрийн асуудал, эрхэлсэн Засгийн газрын гишүүн, дэд хорооны бүрэлдэхүүнийг аймгийн Засаг дарга тус тус батална.

⁸ 6.3 Хороо, дэд хорооны бүрэлдэхүүнд төрийн бус байгууллагын 4 төлөөлөл байна.


Цаашид дэд хорооны хурлын тэмдэглэлийг бүрэн бэлтгэх, төсөлтэй холбоотой анхан шатны баримтад шаардлага хангасан материал бүрдүүлэх, сонгон шалгаруулалтын материалуудыг үе шат бүрээр дарааллаар нь эмх цэгцтэй архивлах шаардлагатай байна.

2.1.2 2019-2020 онд баталсан 10 салбар, чиглэлд 16 төсөлд зээл олгосон байна.

ХХААХҮ-ийн сайдын тушаалаар орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийн хөгжлийг дэмжих салбар, чиглэлийг баталж ирсэн ба аймгийн дэд хороо ЖДҮ-ийг хөгжүүлэх төслийн зээлийг сонгон шалгаруулахдаа тус чиглэлийг баримталж ажилласан байна. Тухайлбал: ХХААХҮ-ийн сайдын 2019 оны А-146 дугаар тушаалаар 14 салбар, 2020 оны А-131 дүгээр тушаалаар 9 салбар чиглэлийг баталсан байна.

Говьсүмбэр аймаг нь ЖДҮХС-гаас 2019-2020 онд дээрх батлагдсан салбар чиглэлүүдээс 10 салбарт нийт 16 ЖДҮ эрхлэгчдэд 1,139.0 сая төгрөгийн зээл олгосон байна.

Дүрслэл №3



ЖДҮ эрхлэгчдийн төслийг хүлээн авч ХХААХҮЯ-наас баталсан салбар, чиглэлийн хүрээнд зээл олгосон байна.

2.1.3 Аймгийн төсөл сонгон шалгаруулах дэд хороо нь төслийг орон нутгийн онцлог, ач холбогдлоор эрэмбэлээгүй байна.

Төсөл сонгон шалгаруулах дэд хороо нь жагсаалтыг ач холбогдлоор нь эрэмбэлдэггүй бөгөөд "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 5 дугаар бүлэгт зааснаар тухайн салбарын манлайлал, бизнесийн туршлага, зах зээлийн багтаамж, өрсөлдөөний байдал, улс төр, эдийн засаг, нийгэм, технологи, импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх байдал, ажлын байр нэмэгдүүлэх, байгаль орчинд ээлтэй байдал, барьцаа хөрөнгө, төсөл хэрэгжих боломж, төслийн танилцуулга зэрэгт үндэслэн онооны системээр үнэлж дүгнэж байна.

2019-2020 онд аймгийн ХХААГ-т иргэн, ААНА-ээс нийт 71 төсөл ирүүлснээс иж бүрдэл дутуу шалтгаанаар иж бүрдэл шалгах явцад 18 төсөл хасагдаж, дэд хорооноос иж бүрдлийн шаардлага хангасан 11 салбарын 53 төсөлд сонгон шалгаруулалт хийж, ЖДҮГ-т хүргүүлсэн байна. /Хавсралт-1/

Төслийн шийдвэрлэлттэй холбоотой тоон мэдээллийг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл №4

2019	Ирүүлсэн төсөл 50 /3,387.5сая/
- Иж бүрдэл дутуу хасагдсан 9 /953.6 сая/ - Дэд хороо эрэмбэлж, ЖДҮГ-т хүргүүлсэн төсөл 41 /2,433.9 сая/ - ЖДҮХС-гаас арилжааны банкаар дамжуулан зээл олгосон төсөл 9 /450.0 сая/ - ЖДҮГ-аас шууд зээл олгосон төсөл 1 /241.0 сая/	
2020	Ирүүлсэн төсөл 21 / 2,045.1 сая/
- Иж бүрдэл дутуу хасагдсан 9 / 799.5 сая/ - Дэд хороо эрэмбэлж, ЖДҮГ-т хүргүүлсэн төсөл 12 /1,245.6 сая/ - ЖДҮХС-гаас зээл олгосон төсөл 6 /448.0 сая/	

Дүрслэлээс харахад аймгийн дэд хорооноос хүргүүлсэн 53 төслөөс онооны эрэмбээр 2019 онд 9 төсөлд, 2020 онд 6 төсөлд ЖДҮХС-гаас зээл олгосон байна. Зээлийн батлагдсан эх үүсвэр хүрэлцээгүйгээс шалтгаалан төсөл сонгон шалгаруулалтад тэнцэж эрэмблэгдсэн хэдий ч 2019 оны 32 төсөл, 2020 оны 6 төсөлд зээл олгоогүй нь тухайн зээл авах хүсэлтэй иргэн, ААН-үүдэд банкны шалгуур өндөр болон уг төслийн санхүүжилтийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалсан байна. Тухайн жилдээ дахин зээлийн санхүүжилтийн эх үүсвэр хуваарилаагүй тохиолдолд төсөл сонгон шалгаруулалтаар эрэмблэгдсэн төслүүд нь ямарч ач холбогдолгүй, дараагийн жилийн төсөл сонгон шалгаруулалтад дахин төсөл бичиж оролцох байдлаар явж ирсэн нь ЖДҮ эрхлэгчдэд хүндрэл бэрхшээл учруулж байна.

2.1.4 Төсөл сонгон шалгаруулалтын үйл явцыг цахимаар нээлттэй, ил тод зохион байгуулсан байна.

Жижиг, дунд үйлдвэрийн төсөл хөтөлбөрийг хүлээн авах болон төсөл сонгон шалгаруулалтын зарыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ЖДҮГ-ын smefund.gov.mn сайтаар орон даяар нэгэн зэрэг мэдээлдэг бөгөөд орон нутгийн “Залуус” телевиз, “Говьсүмбэр” пэйж хуудас, аймгийн ХХААГ-ын цахим хуудсаар олон нийтэд хүргэж хэвшсэн байна. Мөн аймгийн ХХААГ-ын ЖДҮ хариуцсан мэргэжилтэн 2020 оны сонгон шалгаруулалтын зар байршуулахаас өмнө орон нутгийн 150 иргэнд танилцуулга бэлтгэн тараасан байна.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас зээл хүссэн иргэн, аж ахуйн нэгжийн төсөл, холбогдох материалыг хүлээн авч “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу 4 үе шаттайгаар үнэлж сонгон шалгаруулалт хийсэн байна.

Төсөл сонгон шалгаруулалтын үе шатыг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл №5



Дэд хороо нь төслийн сонгон шалгаруулалтыг “Говьсүмбэр” пэйж хуудас, аймгийн ХХААГ-ын цахим хуудсаар видео /Live/ хэлбэрээр шууд дамжуулан мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэж хэвшсэн байна.

2.2 ЖДҮХС-аас олгосон зээлийн 43.9% нь буюу 500.0 сая төгрөгийн зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй байна.


2.2.1 Зээл авах сонирхол бүхий ЖДҮ эрхлэгч иргэн, ААН-ийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох судалгааны ажил хийгдээгүй байна.

Аймгийн ХХААГ-т 2019, 2020 онуудад ЖДҮ эрхлэгчдээс нийт 71 төсөл ЖДҮХС-ийн зээлд хамрагдахаар ирүүлснээс 15 иргэн, ААН нийт 898.0 сая төгрөгийн зээл олгосон байна. Энэ нь зээл авах сонирхол бүхий ЖДҮ эрхлэгчдийн 21.1% нь зээлд хамрагдсан байна. Үүнээс харахад ЖДҮ эрхлэгчдээс хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэл сонирхол их байгаа боловч орон нутагт

хуваарилагдан ирж буй зээлийн хэмжээ бага, мөн төсөл ирүүлсэн ЖДҮ эрхлэгчдийг дараагийн зээлд хэрхэн шат дараалалтайгаар хамруулдаг нь тодорхойгүй байна.

ЖДҮХС-гаас олгож буй зээл зорилтот хэрэглэгчид хүрч чадаж байгаа эсэхэд судалгаа хийгдээгүй бөгөөд аймгийн ХХААГ-аас 2021 онд улсын бүртгэлд бүртгэлтэй бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн, ЖДҮ эрхлэгчээр бүртгүүлсэн иргэн, ААН, ЖДҮХС-гаас 2011-2020 онд зээл авсан иргэн, ААН-ийн гэсэн 3 төрлийн судалгаа хийсэн байна.

Дүрслэл 5



ЖДҮ эрхлэгч иргэн, ААН-ийн хэрэгцээ, шаардлага тодорхойлох судалгааны дүн, дүгнэлт, тайлан гаргаагүй, уг судалгаанд үндэслэн тэдгээрийн эрх ашигт нийцсэн шийдвэр гаргуулах тал дээр дорвитой ажил хийгдээгүй байна.

Цаашид зээл авах сонирхол бүхий ЖДҮ эрхлэгчийн судалгаанд дүн шинжилгээ хийж төрөлжүүлэх, хоршуулах, үйл ажиллагааг илүү өргөжүүлэх зэргээр үйл ажиллагааг үе шаттайгаар үр дүнтэй зохион байгуулах шаардлагатай байна.

2.2.2 ЖДҮХС-аас олгосон 4 төслийн 500.0 сая төгрөгийн зээлийг зориулалт бусаар зарцуулсан байна.

ЖДҮХС-гаас 2019 онд 10 төсөлд 691.0 сая, 2020 онд 6 төсөлд 448.0 сая төгрөгийн зээл олгогдсон байна. Үүнээс 3 төслийн 95.6 сая төгрөгийн зээлийг хугацаанаас нь өмнө төлж дууссан, 8 төслийн 538.4 сая төгрөгийн зээлийн ашиглалт хэвийн бол 4 төслийн 500.0 сая төгрөгийн зээл зарцуулалтын тайлангаараа 40-60%-ийн зарцуулалт тодорхойгүй, төсөлд заасан үйл ажиллагаагаа явуулаагүй, зээлийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

ЖДҮХС-гаас зээлийг хугацаанаас өмнө төлсөн 3 төсөл нь бага хэмжээний зээл авсан тул орлого нэмэгдэх үед зээлийн хэмжээгээ нэмэгдүүлэх зорилгоор банкнаас өндөр дүнтэй зээл авах, гадаад явах болсон, ашиг орлого нэмэгдсэн, дараагийн зээлд хамрагдах зорилгоор зээлийг хаасан байна.

Зээлийн ашиглалт хэвийн, бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдэж, үйл ажиллагаа тогтмолжсон, тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа төслүүдээс дурьдвал:

- “Боржигон нутгийн зураг” ХХК нь - гэрэл зураг, хэвлэлийн үйлчилгээ үзүүлдэг бөгөөд хулдаасан хэвлэл, аяган дээрх хэвлэл, хөргөгчний наалтны хэвлэл зэрэг 3 тоног төхөөрөмж шинээр худалдан авч бүтээгдэхүүний нэр төрлөө нэмэгдүүлсэн байна.

Зураг №1



- Иргэн З.Билэгбаяр – оёдол захиалгын чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд төслийн зээлээр оёдлын үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүхий эд материал

худалдан авч захиалгын болон борлуулалтын тоо нэмэгдсэнээр “Боржигон гоёл” ХХК-ийг үүсгэн байгуулж, үйл ажиллагаагаа өргөжүүлсэн байна.

Зураг №2



- Иргэн А.Сэргэлэн – даавуун дээрх болон арьсан дээрх хэвлэлийн тоног төхөөрөмж худалдан авч бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдүүлж бусад орон нутгаас болох үйл ажиллагаагаа өргөжүүлэн тогтмол ажиллаж байна.

Зураг №3



- “Эрин зууны холбоос” ХХК нь – сав баглаа боодол, цаасан үйлдвэрлэлийн зориулалтаар зээл авсан бөгөөд сав баглаа боодлын хувьд оёдлын үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж худалдан авч оёдол захиалгын тоо нэмэгдсэн байна. Харин цаасны үйлдвэрлэлийн хувьд цаасан уут үйлдвэрлэх тоног төхөөрөмжийг БНХАУ-д захиалсан боловч ковид-19 цар тахлын үед хил хаасантай холбоотой худалдан авах боломжгүй болсон байна. Иймд ЖДҮГ-т албан бичиг хүргүүлэн үйл ажиллагааны чиглэлийг өөрчилж блокны үйлдвэр байгуулж, 2 төрлийн блок үйлдвэрлэж эхэлсэн нь зах зээлээ мэдэрч цаг үеэ олсон шийдвэр болсон бөгөөд орон нутгийн бүтээн байгуулалтад хувь нэмрээ оруулж байна.

Зураг №4



Харин 2020 онд орон нутагт хуваарилагдсан ЖДҮХС-аас олгосон 3 төслийн 259.0 сая, 2019 оны 241.0 сая төгрөгийн 1 зээлийг тус тус зориулалт бусаар зарцуулсан, үйл ажиллагаа явуулаагүй дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. "Чойр нарлаг хүлэмж хоршоо" нь

Дөрвөн улирлын хүнсний ногооны хүлэмж барих төслийн 95.0 сая төгрөгийн зээлийг зориулалт бусаар зарцуулсан бөгөөд ЖДҮГ-аас 2021 оны 7 дугаар сарын 22-ны өдөр хийсэн явцын хяналт шалгалтаар 40%-ийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн хэдий ч аудитын явцад газар дээр нь очиж танилцахад төсөлд заасан үйл ажиллагаа огт хийгдээгүй, үйл ажиллагаа явуулаагүй байна.

Зураг №5



2 "Мэргэн-Дунгаа" ХХК нь

Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл төслөөр 64.0 сая төгрөгийн зээл авсан боловч зээлийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан бөгөөд ЖДҮГ-аас 2021 оны 7 дугаар сарын 22-ны өдөр хийсэн явцын хяналт шалгалтаар 50%-ийн гүйцэтгэлтэй хийгдэж байна гэж дүгнэсэн хэдий ч аудитын явцад үйл ажиллагаагаа танилцуулаагүй, төсөл хэрэгжүүлэгч ААН-ийн захирал нь төмөр замын байгууллагад ажилладаг гэсэн шалтгаанаар удаа дараа дуудсан боловч ирээгүй, тайлбар өгөөгүй, төсөлд заасан үйл ажиллагаагаа огт явуулаагүй байна.

3 "Сүмбэр хишиг" ХХК нь

“Стандарт хадгалат” махны зоорь ашиглалтанд оруулах төслөөр 100.0 сая төгрөгийн зээлийг зориулалт бусаар зарцуулсан бөгөөд ЖДҮГ-аас 2021 оны 7 дугаар сарын 22-ны өдөр хийсэн явцын хяналт шалгалтаар 50%-ийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн хэдий ч аудитын явцад үйл ажиллагаагаа танилцуулаагүй “Очир мөнх хайрхан” ХХК-тай хамтарсан гэсэн тайлбарыг хийж, тухайн ААН-ийн зоорийг үзүүлсэн байна. Төсөлд заасан үйл ажиллагаа огт хийгдээгүй байна.

4 "Чойр кашмер" ХХК нь

ЖДҮГ-аас 2019 онд "Чойр кашмер" ХХК нь “ноос, ноолууран сүлжмэл бүтээгдэхүүн” үйлдвэрлэх эргэлтийн хөрөнгө авах зориулалтаар 241.0 сая төгрөгийн зээл авсан боловч зээлийн эргэн төлөлт хийгдээгүй, үйл ажиллагаа явуулаагүй байна. Энэ зээл нь орон нутгийн төслийн дэд хороогоор дамжаагүй, шууд ЖДҮГ-аас олгосон зээл бөгөөд аймгийн ХХААГ-ын тайлан мэдээнд тусгагдаагүй бөгөөд зээлийн төлөлт хийгдээгүй хугацаа хоцорсон гэсэн мэдээлэл ЖДҮГ-аас ирүүлсэн. Аудитын явцад 2 удаа утсаар холбогдож дуудсан ба зээлтэй холбоотой байгууллагын үйл ажиллагаатай танилцахаар мэдээлэл өгсөн боловч аудитын явцад ирж уулзаагүй, байгууллагын үйл ажиллагааг танилцуулаагүй болно.

Эдгээр нь Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.8⁹, 13.2.9¹⁰, 13.2.10¹¹, Засгийн газрын 2016 оны 138 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэх хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах түр журам”-ын 7 дугаар зүйлийн 7.4¹², Засгийн газрын 2020 оны 113

⁹ 13.2.8 Сангаас олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, зээлийн гэрээний үүргээ биелүүлэх;

¹⁰ 13.2.9 зээлийн зарцуулалтын явц, байдлын талаарх тайланг Санд 6 сар тутам ирүүлэх;

¹¹ 13.2.10 хуулиар хүлээсэн бусад үүрэг

¹² “Бодлогын зээлийг зориулалт бусаар ашигласан нь тогтоогдсон тохиолдолд зээлийн гэрээг цуцлах ажиллагаа хийгдэнэ”

дугаар тогтоолын 16 дугаар зүйлийн 16.5¹³, 16.6¹⁴, ЖДҮГ-ын 2019 оны 12 дугаарын сарын 13-ны өдрийн ЖДҮГ-тай байгуулсан SME-00129, 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн №SME-01605, SME01610, SME-01573 дугаартай зээлийн гэрээний 3 дугаар зүйлийн 3.3¹⁵, 4 дүгээр зүйлийн 4.2¹⁶, 6 дугаар зүйлийн 6.2.1¹⁷, 7 дугаар зүйлийн 7.1.6¹⁸ дахь заалтуудыг зөрчсөн байна.

Иймд дээрх 4 төслийн үндсэн зээл 482.9 сая, зээлийн хүүгийн 14.6 сая төгрөг, нийт 496.9 сая төгрөгийн зээлийг зориулалт бусаар зарцуулсан тул ЖДҮХС-д буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.2.3 ЖДҮХС-д орон нутгийн төсвөөс зээл олгохоор тусгайлан баталсан төсөв байхгүй байна.

2.2.4 Зээлийн эргэн төлөлт, зээлийн хүүгийн орлого хугацаандаа бүрэн төлөгдөхгүй байгаагаас дараагийн жилд хуваарилагдах зээлийн эх үүсвэр буурах эрсдэл үүссэн байна.

ЖДҮХС-гаас 2019 онд 9 төсөлд 450.0 сая төгрөгийн зээлийг арилжааны банкаар дамжуулан олгосон ба зээлийн эргэн төлөлт хэвийн байна. Мөн ЖДҮХС-гаас шууд олгосон зээлийн болон эргэн төлөлтийн мэдээлэл аймгийн ХХААГ-т байгаагүй учраас зээлдэгч нараас болон ЖДҮГ-аас холбогдох мэдээллийг аудитын явцад гаргуулан авсан. Энэ нь төрийн байгууллагуудын уялдаа холбоо хангалтгүй байгааг харуулж байна.

ЖДҮХС-гаас шууд олгосон зээлийн баримтад тулган баталгаажуулалт хийхэд 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 2020 онд олгосон зээлээс “УЦЦЭЧ” ХХК нь зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн бөгөөд нийт 12.6 сая төгрөгийн үндсэн зээл, зээлийн хүүг дутуу төлсөн байна.

Ковид-19 цар тахлаас шалтгаалж, тоног төхөөрөмж, материалын худалдан авалт бүрэн хийгдээгүйтэй холбоотойгоор зарим зээлдэгч нар үйл ажиллагаа явуулаагүй гэсэн шалтгаанаар зээлийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу төлөөгүй байна.

Зээлийн эргэн төлөлтийг хугацаанд нь бүрэн төлөхгүй байгаагаас дараагийн жилд аймаг, орон нутагт хуваарилагдах ЖДҮХС-ийн зээлийн эх үүсвэр бүрдэхгүй байх, дараагийн зээлд хамрагдах хүсэлтэй ЖДҮ эрхлэгчдийн зээл авах боломжийг хаах эрсдэлтэй байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн дүнгээс алданги тооцоогүй, мөн зээлийн эргэн төлөлт дутуу хийгдсэнээс дараагийн зээл олгох эх үүсвэр буурах эрсдэлтэй байна.

Эдгээр нь Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.8¹⁹, 13.2.10²⁰, Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолын 16 дугаар зүйлийн 16.5²¹, 16.6²², ЖДҮГ-ын 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн №SME-01605, SME01610, SME-01615, SME-

¹³ 16.5 Сангаас шууд олгосон зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь Сангийн хяналт, шалгалтаар тогтоогдсон бол зээлдэгчийн эх үүсвэрийг буцаан татаж, холбогдох байгууллагад шилжүүлнэ. Энэ зохицуулалтыг Сан, зээлдэгчтэй байгуулах гэрээгээр нарийвчлан зохицуулна

¹⁴ 16.6 Сангаас зээл авсан этгээд зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй нь тогтоогдсон, зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд Сангаас дахин зээл олгохгүй.

¹⁵ 3.3 Зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөөгүй хугацаа хэтэрсэн тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үнийн дүнгийн үлдэгдэлд 0.1 хувиар алданги тооцно.

¹⁶ 4.2 Зээлдэгч авсан зээлээ энэ гэрээний хавсралт 1-д заасан “Зээлийн эргэн төлөлтийн хуваарь”-ийн дагуу үндсэн зээл, зээлийн хүүгийн аль нэгийг төлөөгүй бол зээлийн төлбөрийг хугацаандаа төлөгдөөгүйд тооцно.

¹⁷ 6.2.1 Зээлийг энэхүү гэрээний 3.1-д заасан зориулалтын дагуу ашиглах

¹⁸ 7.1.6 Зээлдэгч зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй, гэрээний үүргийг зөрчсөн бол уг зээлийн гэрээг хугацаанаас өмнө цуцалж зээлийг бүрэн дүнгээр төлөхийг шаардах

¹⁹ 13.2.8 Сангаас олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, зээлийн гэрээний үүргээ биелүүлэх;

²⁰ 13.2.10 хуулиар хүлээсэн бусад үүрэг

²¹ 16.5 Сангаас шууд олгосон зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй нь Сангийн хяналт, шалгалтаар тогтоогдсон бол зээлдэгчийн эх үүсвэрийг буцаан татаж, холбогдох байгууллагад шилжүүлнэ. Энэ зохицуулалтыг Сан, зээлдэгчтэй байгуулах гэрээгээр нарийвчлан зохицуулна

²² 16.6 Сангаас зээл авсан этгээд зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй нь тогтоогдсон, зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд Сангаас дахин зээл олгохгүй.

01573 дугаартай зээлийн гэрээний 3 дугаар зүйлийн 3.3²³, 4 дүгээр зүйлийн 4.2²⁴, 7 дугаар зүйлийн 7.1.4²⁵, 7.1.6²⁶ заалтуудыг зөрчсөн байна.

Иймд дээрх “УЦЦЭЧ” ХХК-ны 12.6 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүг нэгдсэн журмаар гэрээний заалтын дагуу алдангийн хамт эргэн төлүүлж, ЖДҮХС-д буцаан төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

²³ 3.3 Зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөөгүй хугацаа хэтэрсэн тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үнийн дүнгийн үлдэгдэлд 0.1 хувиар алданги тооцно.

²⁴ 4.2 Зээлдэгч авсан зээлээ энэ гэрээний хавсралт 1-д заасан “Зээлийн эргэн төлөлтийн хуваарь”-ийн дагуу үндсэн зээл, зээлийн хүүгийн аль нэгийг төлөөгүй бол зээлийн төлбөрийг хугацаандаа төлөгдөөгүйд тооцно.

²⁵ 7.1.4 Зээлдэгч зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүй буюу зээлээ хугацаандаа төлөөгүй 90-ээс дээш хоног хэтрүүлэх, зээлийн эргэн төлөлтийн графикийг 3 удаа зөрчсөн тохиолдолд зээлийн гэрээг цуцалж, зээл буцаан төлүүлэх арга хэмжээ авч, барьцааны зүйл болох үл хөдлөх хөрөнгийг шүүхээр шийдвэрлүүлэн шийдвэр гүйцэтгүүлэх журмаар захиран зарцуулах

²⁶ 7.1.6 Зээлдэгч зээлийг зориулалтын дагуу ашиглаагүй, гэрээний үүргийг зөрчсөн бол уг зээлийн гэрээг хугацаанаас өмнө цуцалж зээлийг бүрэн дүнгээр төлөхийг шаардах

БҮЛЭГ 3

ЖДҮГ болон аймгийн ХХААГ-аас төслийн хэрэгжилтэд тавих хяналт үр дүнгүй, зээлийн мэдээллийн цахим системийн зохион байгуулалт, ашиглалт хангалтгүй байна.

3.1 Хэрэгжсэн төслүүдээс орон нутгийн бренд бий болоогүй ч 68.7% нь үйл ажиллагаа нь өргөжиж, бүтээгдэхүүний нэр төрлөө нэмэгдүүлсэн байна.

3.1.1 Аймгийн ХХААГ-аас зээлд хамрагдсан ЖДҮ эрхлэгчдийн хэрэгжүүлсэн төслийн хүрэх түвшин, зорилтот түвшинг тооцож, үр дүнг үнэлээгүй байна.

3.1.2 ЖДҮХС-гаас зээл авсан ЖДҮ эрхлэгчид орон нутгийн бренд бүтээгдэхүүнээр тодорхойлох хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэл хийгээгүй байна.

2019-2020 онд ЖДҮХС-гаас зээл авсан 11 ЖДҮ эрхлэгч үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж худалдан авч, бүтээгдэхүүний нэр, төрөл нэмэгдэж үйл ажиллагаа нь өргөжсөн байна. Тухайлбал: блокны үйлдвэр, даавуун дээрх хэвлэл, арьсаар хийсэн бүтээгдэхүүн дээрх хэвлэл, том хэмжээний зураг хэвлэл, хөргөгчний наалт гэх мэт үйлдвэрлэлүүд тогтмол үйл ажиллагаагаа явуулж байна.

Эдгээрээс орон нутгийн бренд бүтээгдэхүүнээр тодорхойлох хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэл хийгдээгүй байна.

Орон нутгийн бренд бүтээгдэхүүн болох боломжтой төслийг сонгон шалгаруулж үйлдвэрлэл нэмэгдсэнээр чанар, үзэмж сайжирч тухайн орон нутгаар дайран өнгөрч байгаа иргэдийн худалдан авалт нэмэгдэх, ЖДҮ эрхлэгчдийн орлого нэмэгдэх сайн талтай юм.

Цаашид орон нутгийн бренд бүтээгдэхүүнийг бий болгох, үйл ажиллагаа нь тасралтгүй үргэлжлэх боломжтой төсөл хөтөлбөрийг шалгаруулах, төслийн зорилтот түвшин хүрэх үр дүнг тооцож, үнэлдэг байх шаардлагатай байна.

3.1.3 Зээлд хамрагдсан нийт иргэд, ААН-ийн 37.5% буюу 6 нь үйл ажиллагаа жигдэрсэн байна.

Зээлд хамрагдахаар хүсэлт гаргасан идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа ААН, иргэдийн хүссэн зээлийг олгоогүй бөгөөд тухайн төслийн тооцоололд бодитой хандах шаардлага үүсэж байна. Мөн зээлийн барьцаанаас шалтгаалан зээлийн дүнг бууруулж олгосон нь төлөвлөсөн ажлыг бүрэн гүйцэтгэж чадахгүй байна.

2019-2020 онд зээл авсан ЖДҮ эрхлэгчдийн 5 буюу 31.2% нь тогтвортой үйл ажиллагаа чадахгүй байна. Энэ нь улирлын чанартай үйл ажиллагаа явуулж байгаатай холбоотой байна.

Аудитын явцад ЖДҮХС-гаас зээл авч ЖДҮ эрхэлж байгаа 7 зээлдэгчтэй уулзалт ярилцлага хийж, 11 зээлдэгчийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцлаа.

2019, 2020 онуудад ЖДҮХС-аас зээл авсан нийт 16 төслөөс 11 буюу 68.7% нь тодорхой хэмжээгээр үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд 6 буюу 54.5% нь тогтмолжиж, тасралтгүй үйл ажиллагаагаа явуулж байгаа бол 5 буюу 45.5% нь улирлын чанартай үйл ажиллагаа явуулж байна.

Тус зээлдэгч нарын сүүлийн 3 жилийн санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийж, 2019-2021 онд борлуулалтын орлогын үзүүлэлтийг дүрслэлээр харуулбал:

2019 оны 9 зээлдэгчийн борлуулалтын орлогыг харьцуулахад

2018-2019 онд 3 дахин нэмэгдсэн,
2019-2020 онд 8%-иар,
2020-2021 онд мөн 8%-иар тус тус буурсан

2020 оны 6 зээлдэгчийн борлуулалтын орлогын харьцуулахад

2019-2020 онуудад 2.5 дахин,
2020-2021 онд 8%-иар,
2020-2021 онуудад 19%-иар тус тус буурсан

Дүрслэлээс харахад: ЖДҮ эрхлэгч нарын жилийн борлуулалтын орлого буурсан хэдий ч үйл ажиллагаагаа тасалдуулахгүй явуулж байгаа, Татварын хэлтэст үйл ажиллагаагаа ААН-ээр тайлагнахаас илүүтэй иргэнээр тайлагнах хандлагатай байна. Үүнтэй холбоотойгоор орлого буурсан харагдах магадлалтай байна.

Цаашид орон нутгийн оролцоог хангаж ЖДҮХС-аас зээл авсан ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааг тогтмолжуулах, зээлийн үр ашгийг сайжруулах шаардлагатай байна.

3.1.4 2019-2020 онд зээл авсан ЖДҮ эрхлэгчид 84 ажлын байр нэмэгдүүлэхээр төсөлдөө тусгасан боловч төлөвлөсөн ажлын байр нэмэгдээгүй байна.

2019-2020 онд ЖДҮХС-аас зээл олгосон 15 зээлдэгч нь нийтдээ 84 ажлын байр нэмэгдүүлэхээр төсөлдөө тусгаж зээлд хамрагдсан боловч төслийг хэрэгжүүлснээр төлөвлөсөн ажлын байр нэмэгдээгүй байна. Түүнчлэн төсөл хэрэгжүүлсэн ЖДҮ эрхлэгч нар төсөлд ажлын байрыг их хэмжээгээр нэмэгдүүлэхээр тусгасан боловч бодит нөхцөл байдал дээр ажлын байр огт нэмэгдээгүй, энэ нь зээл авахын тул хийсвэрээр өсгөсөн тоо бөгөөд зөвхөн өөрсдийн ажлын байрыг л хадгалж үлдсэн байна.

Төсөлд тусгагдсан ажлын байрны тоог зээл авснаас хойшхи ажлын байрны тоотой харьцуулан Нийгмийн даатгалын тайлантай тулган баталгаажуулахад 82% нь буурсан үзүүлэлттэй гарсан. Үүнд: ажиллах хүчний хомсдолтой байдлаас түр ажиллаж буй ажилтнууд НДШ төлөхгүй байх сонирхолтой болсон нь нөлөөлсөн байна. /Хавсралт №2/

Ажлын үнэлгээ бага, иргэдийн ажил хийх сонирхол буурсан, ковид-19 цар тахлаас шалтгаалан үйл ажиллагаа явуулаагүй зэрэг нь нөлөөлсөн боловч ажиллах хүчний хомсдол, улирлын чанартай ажлын болон гэрээгээр ажиллуулсан ажилчид нь НДШ төлснөөр халамжийн үйлчилгээнээс хасагддаг гэсэн шалтгаанаар НДШ төлөх сонирхолгүй болсонтой холбоотой байна. Ажлын байр нэмэгдүүлэхэд жижиг ААН-үүдэд НДШ өндөр төлж байгаа нь дарамт болсон байх үндэслэлтэй байна.

Ажлын хөлсний үнэлгээ бага, нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ өндөр зэргээс шалтгаалан НДШ төлөгдөхгүй байгаа нь ажлын байрны тоог бодитоор гаргахад хүндрэл учруулж байна.

Хариуцлагын тогтолцоог төлөвшүүлэх, гэрээний үүргийг хангуулах, төлөвлөсөн ажлын байр нэмэгдээгүй, үйл ажиллагаа явуулаагүй зээлдэгч нарын зээлийг бүрэн төлүүлэх шаардлагатай байна.

3.2 ЖДҮГ болон аймгийн ХХААГ-аас төслийн хэрэгжилтэд тавих хяналт үр дүнгүй, зээлийн мэдээллийн цахим системийн ашиглалт, хүчин чадал хангалтгүй байна.

3.2.1 Зээлийн гэрээнд орон нутгийн оролцоо огт тусгагдаагүйгээс төрийн байгууллага хяналтын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх боломжийг хязгаарласан байна.

Аймгийн ХХААГ-аас журмын дагуу хяналтын чиг үүргийг жилд 1-ээс доошгүй удаа хэрэгжүүлэхээр заасан боловч хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, хяналт хийсэн гэх боловч үр дүн муутай байна. 2019-2021 онуудад зээлдэгч нарын үйл ажиллагаанд 1 удаагийн хяналт шалгалт хийгдсэн байна. Мөн тухайн байгууллагаас хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх талаар зээлдэгчийн гэрээнд тусгайлан заагаагүй нь учир дутагдалтай байна.

Аймгийн ХХААГ-аас ирүүлсэн 2019, 2020, 2021 оны ЖДҮ-тэй холбоотой баримт материалуудад 2021 оны 7 сарын 28-ны өдрийн 1 удаагийн хийсэн хяналт шалгалтын тайланг архивласан байна. Уг хяналт шалгалтын тайланд зөвхөн хяналт шалгалт хийсэн явцын мэдээлэл тусгагдсан байна. Аймгийн ХХААГ-аас хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд үүсч буй хүндрэл бэрхшээлийг шийвэрлүүлэх талаар холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд албан ёсоор санал хүргүүлээгүй, шаардлагатай асуудлыг шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Аймгийн ХХААГ-аас хийгдсэн хяналт шалгалт үр дүнгүй, журмын дагуу тухай бүрт хяналт шалгалтыг бүрэн хийгээгүй, алдаа зөрчлийг нэгтгэн дүгнээгүйгээс гадна ЖДҮГ-т хяналт, шалгалтын дүн, тайланг мэдээг хүргүүлээгүй байна.

Иймд аймгийн ХХААГ-аас хяналт шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, давтамжийг нэмэгдүүлэх, хяналт шалгалтын тайланг боловсруулж архивлах, зөрчил арилгуулах зөвлөмж, дүгнэлтийг зээлдэгч нарт хүргүүлж, хэрэгжилтийг тооцож ажиллах шаардлагатай байна.

3.2.2 ЖДҮГ-аас жил бүр явцын хяналт шалгалт хийсэн боловч шалгалтын тайлан мэдээг аймгийн ХХААГ-т ирүүлдэггүй, зээлийн мэдээллийн цахим системийг боловсронгуй болгох шаардлагатай байна.

ЖДҮГ-аас хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн эсэх тодорхойгүй байгаа бөгөөд явцын хяналт шалгалтыг жил бүр хийдэг гэсэн тайлбар өгсөн боловч тайлан мэдээ орон нутагт ирүүлээгүй байна. Тухайлбал: аймгийн ХХААГ-т 2019, 2020 онуудын ЖДҮХС-гаас олгосон зээлийн эргэн төлөлтийн мэдээлэл, ЖДҮГ-аас хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн талаар шалгалтын баримт байхгүй бөгөөд зээл олгосноос хойш ямар давтамжтай, хэдэн удаагийн хяналт шалгалт хийгдсэн нь тодорхойгүй, орон нутагт ажилласан шалгалтын тайланг ирүүлээгүй байна.

ЖДҮГ нь ЖДҮХС-ийн Зээлийн мэдээллийн цахим системийг 2019 оноос ашиглаж эхэлсэн бөгөөд уг системд анхаарах асуудал, зөвлөмжийн мэдээлэл оруулсан боловч тухайн мэдээллийг шалгагдагч байгууллага харах боломжгүй, уг системийн хүчин чадал муу, зээлдэгчийн болон зээлийн мэдээлэл зөрүүтэй, зээлийн эргэн төлөлтийн мэдээлэл оруулах цэсгүй, орон нутгийн мэргэжилтэнд хяналт тавих боломжгүй, холбогдох тайлан мэдээг хэвлэж архивлах боломжгүй байна. Мөн системийн хяналтын хэсэгт оруулсан мэдээлэл нотлох баримтаар баталгаажаагүй, цаашид хэрхэн ажиллах тухай зөвлөмжийг зээл авсан иргэд, ААН-д хүргүүлээгүй байна.

Иймд Зээлийн мэдээллийн цахим системийг боловсронгуй болгох, орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, хяналт, шинжилгээ үнэлгээний дүн болон явцын хяналтын тайлан, зөвлөмжийг аймгийн ХХААГ, зээл авсан иргэн, ААН-үүдэд албан ёсоор хүргүүлж, хэрэгжилтийг тооцож ажиллах шаардлагатай байна.

3.2.3 Орон нутгаас хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх мэдээ, тайланг ЖДҮГ-т хүргүүлээгүй байна.

Аймгийн ХХААГ-ийн ХХААГ-ын ЖДҮ хариуцсан мэргэжилтэн 2019 онд ЖДҮ эрхлэгчдээс ирүүлсэн төсөл, төслийн сонгон шалгаруулалтын болон шалгарсан төслийн талаарх мэдээг ЖДҮГ-т хүргүүлсэн бол 2020 онд төслийг иргэн, ААН зээлийн мэдээллийн цахим системд оруулдаг болсон тул мэдээг бичгээр хүргүүлээгүй байна.

2019, 2020 онуудад аймгийн ХХААГ-аас ЖДҮ эрхлэгчдийн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жилд 2 удаа нэгтгэн ЖДҮГ-т хүргүүлэхээр Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолын хавсралт “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 17 дугаар зүйлийн 17.1-д заасан боловч уг тайланг бэлтгэн хүргүүлсэн эсэх тодорхойгүй байгаа ба гүйцэтгэлийн төлөвлөгөөний ЖДҮ-тэй холбоотой арга хэмжээний хэрэгжилтэд тайлагнасан байна.

Мөн ЖДҮХС-гаас зээл авсан ЖДҮ эрхлэгчид улирал тутам ажлын гүйцэтгэл, үйл ажиллагааны тайланг ЖДҮГ-т хүргүүлэхээр зээлийн гэрээнд тусгагдсан боловч нийт 16 зээлдэгчээс 1 зээлдэгч хүргүүлсэн байна. Тайланг хүргүүлээгүй байхад ЖДҮГ-аас арга хэмжээ авч ажиллаагүй байна.

3.2.4 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ЖДҮГ нь нэгтгэн мэдээлдэг байна. Орон нутагт тусгайлан төсөв хөрөнгө батлагдаж ирдэггүй, ЖДҮГ-т нэгдсэн данстай, уг дансаар санхүүжилт хуваарилагддаг тул, тусгайлан мэдээлэх цэс байхгүй байна.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 509.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, 12.6 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 1 албан шаардлага, 496.9 сая төгрөгийн 1 төлбөрийн акт хүргүүлж, 4 зөвлөмж өгч, УАГ-т уламжлах 3 санал хүргүүлэв.

ДҮГНЭЛТ

Бүлэг-1

1. Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр төрөөс баримталж буй бодлого, эрх зүйн зохицуулалтууд бүрэн хэрэгжиж чадаагүй нь ЖДҮГ болон аймгийн ХХААГ-тай уялдаа холбоотой ажиллаагүйтэй холбоотой байна.

Бүлэг-2

2. ЖДҮХС-аас олгосон зээлийн 43.9% нь үр дүнгүй зарцуулагдаж, сонгон шалгаруулсан төсөл хэрэгжээгүй байна.

Бүлэг-3

3. ЖДҮГ болон аймгийн ХХААГ-аас төслийн хэрэгжилтэд тавих хяналт үр дүнгүй, зээлийн мэдээллийн цахим системийн зохион байгуулалт, ашиглалт хангалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аймгийн Засаг даргад:

1. Аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 4.5.2 дахь заалтыг жилийн төлөвлөгөөнд дэлгэрэнгүй тусгаж, хэрэгжилтийг тооцох

Аймгийн ХХААГ-т

2. Орон нутгийн бренд бүтээгдэхүүнийг бий болгох, үйл ажиллагаа нь тасралтгүй үргэлжлэх боломжтой төсөл хөтөлбөрийг шалгаруулах, төслийн зорилтот түвшин хүрэх үр дүнг тооцож, ач холбогдлоор нь үнэлэх, дэд хорооны хурлын тэмдэглэлийг бүрэн бэлтгэх, төсөлтэй холбоотой анхан шатны баримтад шаардлага хангасан материал бүрдүүлэх, зээл авах сонирхол бүхий ЖДҮ эрхлэгчийн судалгаанд дүн шинжилгээ хийх, сонгон шалгаруулалтын материалуудыг үе шат бүрээр дарааллаар эмх цэгцтэй архивлах
3. Хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд үүсэж буй хүндрэл бэрхшээлийг шийдвэрлүүлэх талаар дээд шатны эрх бүхий байгууллага, албан тушаалтанд албан ёсоор санал хүргүүлж, шаардлагатай асуудлыг шийдвэрлүүлэх
4. Хяналт шалгалтын давтамжийг нэмэгдүүлж үр дүнтэй хэрэгжүүлэх, хяналт шалгалтын тайланг боловсруулж архивлах, зөрчил арилгуулах зөвлөмж, дүгнэлтийг зээлдэгч нарт хүргүүлж, хэрэгжилтийг тооцож ажиллах, ЖДҮХС-аас зээл авсан ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааг тогтмолжуулах, зээлийн үр ашгийг нэмэгдүүлэх, төлөвлөсөн ажлын байр нэмэгдээгүй, үйл ажиллагаа явуулаагүй зээлдэгч нарын зээлийг буцаан бүрэн төлүүлэх арга хэмжээ авах

ДЭЭД ШАТНЫ БАЙГУУЛЛАГАД ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

“Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны үр нөлөө”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын үр дүнд бодлогын түвшинд нэгтгэн шийдвэрлэх дараах асуудлууд байна. Үүнд:

1. ЖДҮГ болон аймгийн ХХААГ-ын ажлын уялдаа холбоог сайжруулах, Үүнд: Орон нутгийн төсөл сонгон шалгаруулах дэд хороогоор дамжаагүй ЖДҮГ-аас шууд олгож буй зээлийн мэдээллийг аймгийн ХХААГ-т тухай бүр мэдэгдэх, хяналтын тайлан, зөвлөмжийг аймгийн ХХААГ болон зээл авсан иргэн, ААН-үүдэд албан ёсоор хүргүүлж, хэрэгжилтийг тооцож ажиллах
2. ЖДҮХС-гаас олгож буй зээлийн гэрээнд, аймгийн ХХААГ-ын эрх үүргийг тусган, гурвалсан байдлаар зохицуулалт хийж орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх
3. ЖДҮГ-аас хийж буй хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж, гэрээний үүргийг бүрэн хангуулах, зээлийн мэдээллийн цахим системийг боловсронгуй болгох

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН
САНАЛ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР

42011 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,
Найрамдал хотхон, Утас: 7054 3261,
И-мэйл: hhaagg53@yahoo.com

2022.10.28 № 01/213
танай 2022.10.24-ны № 170 -т

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл
ажиллагааны үр нөлөө” гүйцэтгэлийн аудитын
урьдчилсан тайлантай танилцаж тайлбар, саналыг
хүргүүлэв.

Хавсралт 2.. хуудастай.

ДАРГА



Н.ДАВААХҮҮ

С. Батмунхуй
Саналтай танилцаж,
тайланг зөхсөн
Батмунхуй
37
628

“Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны үр нөлөө”
гүйцэтгэлийн аудитын урьдчилсан тайланд оруулах санал, тайлбар

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хийсэн гүйцэтгэлийн аудитын урьдчилсан тайлантай танилцлаа. Тайланд дурдсан зарим асуудалд дараах тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

1. “Кластераар хөгжүүлэх бодлого, чиглэлийн талаар аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан боловч хэрэгжилт хангалтгүй байна.” гээд 2016-2020, 2020-2024 оны аймгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдаагүй бөгөөд ... таван жилийн үндсэн чиглэлийн зорилтын хүрээнд хийх ажлыг нарийвчлан төлөвлөөгүйгээс хэрэгжилт хангалтгүй байна гэж дүгнэжээ:

Тайлбар, санал:

Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл нь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн дараа төлөвлөгдсөн тул өмнөх төлөвлөгөөний зорилтыг базаж, үр дүнгээр нь зорилтоо төлөвлөсөн болно. Кластераар хөгжүүлэх бодлогын зорилтоос аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтууд хазайхгүй. Тухайлбал: “... бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын тогтолцоог кластерийн зарчмаар хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ” гэдэгт аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “3.3.1. Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийн нөөц ашиглалтыг сайжруулж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах хувь хэмжээг нэмэгдүүлэх” зорилт дэвшүүлж, жил бүрт буюу богино хугацаанд -төллөсөн хээлтэгчийг саалинд бүрэн хамруулж, сүү үйлдвэрлэлийг, -хонь, үхрийг махны чиглэлээр өсгөж, махны үйлдвэрлэлийг, -махны чиглэлээр өсгөхдөө хээлтүүлэгчийн хүрэлцээгүйг биотехнологийн аргаар буюу зохиомол хээлтүүлэг хийж нөхөх; - газар тариалангийн эргэлтийн талбайг нэмэгдүүлэх; -хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлэх; ... гэх мэтээр төлөвлөсөн.

Эдгээр түүхий эд бэлтгэх, нөөцөө нэмэгдүүлэх зорилгоо хүнсний аюулгүй байдлаа хянах тогтолцоогоор уялдуулан “дотооддоо үйлдвэрлэсэн мах, сүүг биоаюулгүйн 3 дугаар зэрэглэлийн лабораторид 2 жилд 1 удаа баталгаажуулан, үлдэгдлийг тодорхойлуулах;

- дотооддоо үйлдвэрлэж буй төмс, хүнсний ногооны үр сорт, талбайн хорио цээрийн үзлэг, бүтээгдэхүүнийг лабораторид баталгаажуулах арга хэмжээнүүдийг жил бүр төлөвлөн хэрэгжүүлж байна. Мөн бэлтгэсэн түүхий эдийг хадгалах агуулах, зоорийг нэмэгдүүлэх, агуулах зоорийн стандарт, эрүүл ахуйн шаардлагыг хангуулах чиглэлд жил бүр 3-4 арга хэмжээг хэрэгжүүлдэг. Борлуулалтыг уялдуулан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг борлуулах, борлуулалтын цэг тогтоох, үзэсгэлэн худалдааг зохион байгуулах, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сурталчлах арга хэмжээнүүдийг, түүхий эдийг тээвэрлэх, хүнсний

нийлүүлэлтийг уялдуулж, хүнсний томоохон дэлгүүр, жижиг дэлгүүрийн барааг тээвэрлэх автомашиныг захиалга, тээвэрлэлтээр зохицуулж, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх зохицуулалт хийсэн бөгөөд ковид 19 гэх мэт онцгой тохиолдолд бүртгэлжүүлэн зохицуулалт хийдэг болсон. Дээрхи бүх арга хэмжээ нь кластерийн нөхцөлийг бүрдүүлэх агуулгаас зөрөхгүй болохыг тайлбарлаж байна. /дан ганц үйл ажиллагаагаар нь төрөлжүүлэхийг кластер гэж ойлгох нь ерөөсгөл болно./

2. ЖДҮ-ийг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлд төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхойлсон боловч ЖДҮГ болон аймгийн ХХААГ-уудын ажлын уялдаа холбоо хангалтгүй байна., ЖДҮХС-аас хуваарилан олгох хөрөнгийн төлөвлөлтөд орон нутгийн оролцоо байхгүй байна гэжээ.

Тайлбар, санал:

Мөрдөгдөж буй Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлд Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч гэсэн хэсэг байгаа болно. Харин тухайн хуулийн 5 дугаар бүлэг 17, 18 дугаар зүйлд ЖДҮ-ийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын, Нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын бүрэн эрх тусгагдсан. Энд заасан эрх хэмжээний хүрээнд жил бүр буюу дэд хөтөлбөрийн арга хэмжээнд 2019 онд 28.0 сая.төг, 2020 онд 25.0 сая.төг гэхчилэн хөрөнгө тусгуулан, хэрэгжилтийг тайлагнаж байна. Салбарын болон аймгийн дунд хугацааны төлөвлөлт, салбарын болон төрөөс хэрэгжүүлж буй зорилт арга хэмжээний хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд арга хэмжээгээ тусган, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болно.

Мөн ЖДҮ-аас программыг гүйцэтгэгч компаниар хөгжүүлэлт хийлгэх процесс нь үргэлжилж байгаа бөгөөд манай зүгээс программын хэрэглээнд гарч буй доголдол, хэрэглэхэд бэрхшээлтэй бүхий л асуудлыг тухай бүрд нь тавьж, сайжруулах, хэрэглээний сургалтуудыг 2-3 удаа зохион байгуулах зэргээр хамтран ажилласан. Программд хэн мэдээлэл оруулах, хэн хянах, хэн ямар түвшинд хэрхэн оролцоотой байх тал дээр программыг эзэмшигч болон бизнес эрхлэгчдийн мэдээллийн нууцтай холбоотойгоор хязгаарлалт байдаг тул манай байгууллага үүнийг дангаараа бүтэн системээр нь харуулах, ач холбогдлыг бүтнээр нь тайлбарлах бололцоогүй байна. Иймд холбогдох зөвлөмж, албан шаардлагыг агентлагт нь хүргүүлүүлэх саналтай байна.

3. 2019-2020 оны дэд хороо 5 удаа хуралдаж, 4 тогтоол, 2 тэмдэглэл хөтөлж, архивласан байна гэжээ.

Тайлбар, санал:

2019 оны төсөл сонгон шалгаруулах дэд хороо нь олон төсөл танилцуулагдаж, үйл ажиллагаа нь дараа хоногтоо дамжин үргэлжилсэн ба дэд хорооны тухайн өдрийн хурлын эхэнд дэгээ баталж, үргэлжлүүлэн сонгон шалгаруулалтаа хийгээд, оноо, жагсаалтаа үргэлжлүүлэн баталсан тул тогтоол дэс дараалсан дугаараар гарч, хуралдааны тэмдэглэл 1 байгаа болно.



ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Тайлангийн төсөлтэй танилцаад шалгагдагч байгууллагуудаас ирүүлсэн санал, тайлбартай танилцаж тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Хавсралт №1

Дэд хорооноос иж бүрдлийн шаардлага хангаж
ЖДҮГ-т хүргүүлсэн 11 салбарын 53 төсөл /салбар, чиглэлээр/

№	ХХААХҮС-ын 2019-2020 онд ЖДҮХС-гаас зээл олгох салбар чиглэл	ААН /тоогоор/	Иргэн /тоогоор/
1	Арьс шир боловсруулах	1	1
2	Сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах	5	
3	Мал амьны тэжээл үйлдвэрлэх		1
4	Мах махан бүтээгдэхүүн дайвар бүтээгдэхүүн боловсруулах	3	
5	Оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэх	1	2
6	Мод модон бүтээгдэхүүн үйлдвэрлэх	2	3
7	Сав баглаа боодол үйлдвэрлэх	1	1
8	Туслах аж ахуй		3
9	Аялал жуучлал зоогийн өргөө	1	
10	Зоорь, хүлэмжийн аж ахуй	4	
11	Бусад салбар	4	20
Нийт дүн		22	31

**ЖДҮХС-гаас зээл авсан ЖДҮ эрхлэгчдийн
ажлын байрны судалгаа /төсөл тус бүрээр/**

Д/д	ЖДҮ эрхлэгчдийн нэр	Төсөл хэрэгжүүлэх чиглэл	Олгосон зээл /сая.төг/	Ажлын байр	
				Төслөөр ирүүлсэн	НДШ тайлагнасан
Аж ахуйн нэгж					
1	Очир мөнх хайрхан ХХК	Мах махан болон дайвар бүтээгдэхүүн үйлдвэрлэх.	35.6	3	2
2	Боржигин нутгийн зураг ХХК	Гэрэл зураг хэвлэлийн үйлчилгээ-хулдаасан хэвлэл	50.0	5	2
3	Сүмбэр буянт ХХК	Мах махан болон дайвар бүтээгдэхүүн үйлдвэрлэх.	150.0	10	3
4	Мөнх Авзага хайрхан ХХК	модон эдлэл үйлдвэрлэл	43.4	4	1
5	Боржигон гоёл ХХК	оёдол захиалга	35.0	4	3
6	Жанжин чойрын Бөхбат хийц ХХК	модон эдлэл үйлдвэрлэл	30.0	3	1
7	Чойр нарлаг хүлэмж хоршоо	Хүлэмж	95.0	6	-
8	УЦЦЭЧ ХХК	дайвар бүтээгдэхүүн хагас болон бүтэн боловсруулах	71.0	9	2
9	Сүмбэр хишиг ХХК	зоорийн барилга барьж дуусгах тоног төхөөрөмж авах	100.0	9	1
10	Эрин зууны холбоос ХХК	Сав баглаа боодол үйлдвэрлэх	60.0	7	2
11	Чойрын богд шүтээн ХХК	Аялал жуулчлал /Зоогийн өргөө	58.0	13	3
12	Мэргэн Дунгаа ХХК	Сүү, сүүн бүтээгдэхүүн	64.0	5	-
Иргэн					
1	Адьяадорж Сэргэлэн	Арьсан эдлэл үйлдвэрлэл жааз бэлэг дурсгал	40.0	4	-
2	Г.Мөнход	цаасан хайрцаг сав баглаа боодол	20.0	1	-
3	Эрдэнээ Мөнхзул	өргөтгөл/мужааны цех	46.0	1	-
НИЙТ ДҮН			898.0	84	20